

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар
сарын 30 -ны өдөр

№ 01/25

Улаанбаатар хот

Г *Хурлын ирцийг тухай* 7

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу ЭМ ЭН ДИ ХК-ийн 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Эм Эн Ди” ХК -ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр нь 2025 оны 04-р сарын 09-ны өдөр байсныг дурдсугай.

Хоёр. “Эм Эн Ди” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 97,360 ширхэг байснаас хурлын материалтай урьдчилсан танилцсан санал өгөх арга хэлбэрээр энгийн хувьцааны 34,265 хувийг эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч, 04-р сарын 30-ний өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 33,000 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч нийт ирц 67 хувь болж хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:



Н.ГАНЧИМЭГ

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар
сарын 30-ны өдөр

№ 02/25

Улаанбаатар хот

Г

Г

ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай:

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Эм Эн Ди” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Эм Эн Ди” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг сунгасугай.

Үүнд: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр:

1. Намсрайн Отгон-Од
2. Пионг Чунг Фах (Piong Choong Fah)
3. Чунг Чин Иенн (Chung Chee Yenn)
4. Б.Сүнчигмаа
5. Н.Ганчимэг
6. Н.Гансувд

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Ц.Болд
2. Н.Ганбаатар
3. Б.Сарнай

Хоёр. “Эм Эн Ди” ХК-ийн хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Үүнд:

1. “ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
1. Гансувд /Дарга/ 2. Отгон-од 3. Сарнай
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
1. Болд /Дарга/ 2.Отгон-Од 3.Гансувд
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
1. Отгон-Од 2.Ганбаатар 3.Сарнай

Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Н.ГАНЧИМЭГ/

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар
сарын 30-ны өдөр

№ 03/25

Улаанбаатар хот

Г

7

*Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны үйл ажиллагааны тайланг
батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дэх заалт, ЭМ ЭН ДИ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ЭМ ЭН ДИ” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй болохыг тэмдэглэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:



/Н.ГАНЧИМЭГ/

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар
сарын 30-ны өдөр

№ 04/25

Улаанбаатар хот

Г

Г

*Гүйцэтгэх захирлын бүрэн эрх,
цалин урамшуулал*

Компанийн тухай хуулийн 62 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Тус компанийн Гүйцэтгэх захирал Намсрайн Отгон-Од-ын бүрэн эрхийг сунгаж,
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу цалин урамшууллыг тооцон
олгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Н. ГАНЧИМЭГ/

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар
сарын 30-ны өдөр

№ 05/25

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15 дах хэсэг “ЭМ ЭН ДИ” ХК-ийн дүрэм болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 30-ны өдрийн ээлжит хурлаас шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд заасан үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл Фермерийн аж ахуй, Түргэн хоолны үйлчилгээ, Түрээсийн үйлчилгээ гэсэн заалтуудаас хасч, Гэрээгээр өрөмдлөгө хийх, Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх болгон өөрчилсүгэй.
2. Үйл ажиллагааны чиглэл нэмэгдсэнтэй холбоотойгоор компанийн дүрмийн нэмэлтийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон Санхүүгийн зохицуулах хороонд аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Н.Отгон-Од)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Н.ГАНЧИМЭГ/

"ЭМ ЭН ДИ" ХК-ийн 2025 оны 04 сарын 30-ний
өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын ...~~3~~ тоот т огтоолын Хавсралт №1



Компанийн дүрэмд оруулах өөрчлөлт

Дүрмээс хасах

1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо Махатма гандийн гудамж Галакси тауэр 605 тоот хаягыг хасч

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.4. Компани нь энэ дүрмийн 3.3-т заасан үндсэн үйл ажиллагаанаас гадна дараах төрлийн үйл ажиллагааг эрхэлж болно. Үүнд:

- 3.4.1 Фермерийн аж ахуй
- 3.4.2 Түргэн хоолны үйлчилгээ
- 3.4.3 Түрээсийн үйлчилгээ гэсэнг хасч

Дүрэмд нэмэх

1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Стадион оргил, Чингисийн өргөн чөлөө, Хаан тауэр 203 тоот хаягаар бүртгүүлэх,

2.4. Компани нь энэ дүрмийн 3.3-т заасан үндсэн үйл ажиллагаанаас гадна дараах төрлийн үйл ажиллагааг эрхэлж болно. Үүнд:

- 3.4.1 Гэрээгээр өрөмдлөгө хийх
- 3.4.2 Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх гэсэнг нэмэх

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 дугаар
сарын 30-ны өдөр

№ 06/25

Улаанбаатар хот

Г

1

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны
зардлын төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх хэсэг, 2025 оны 04 сарын 30-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай.

Д/д	Зардлын төсөв	Нийт зардал /төгрөг/
1	Бичиг хэргийн зардал	500,000
2	ТУЗ-ийн хурлын зардал	500,000
3	Хувьцаа эзэмшигчдийн хурал	1,000,000
4	ТУЗ-ийн гишүүдийн цалин /жилээр/	36,000,000
	Нийт дүн	38,000,000

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтуяа-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ГАНЧИМЭГ